



“ТАВАН ТОЛГОЙ ТҮЛШ” ХХК ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2019 оны 11 сарын 20 өдөр

Дугаар А/136

Улаанбаатар хот

Журам батлах тухай


Монгол улсын Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.10 дахь заалт, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.3.1 дэх заалт, Эрүүл мэндийн сайдын 2014 оны 10 дугаар сарын 21-ний өдрийн 340 тоот тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хяналтын хэсгийн ажиллах журам”-ыг 1 дүгээр хавсралтаар, “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хяналтын журам”-ыг 2 дугаар хавсралтаар, “Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын бүртгэлийн хяналтын журам”-ыг 3 дугаар хавсралтаар, “Үйлдвэрийн бүсэд замын хөдөлгөөнд оролцох журам”-ыг 4 дүгээр хавсралтаар, “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн эрсдэлийн үнэлгээний журам”-ыг 5 дугаар хавсралтаар, “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн заварчилгаа өгөх журам”-ыг 6 дугаар хавсралтаар, “Яаралтай тусламжийн нэгжийн ажиллах журам”-ыг 7 дугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. Дээрх журмуудыг “Таван толгой түлш” ХХК-ийн нийт ажилтан албан тушаалтан, гэрээт болон туслан гүйцэтгэгч байгууллага, тэдгээрийн ажилтнууд батлагдсан өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.
3. Дээрх журмуудын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Хууль эрхзүй, аудитын алба болон Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хяналтын хэсэгт үүрэг болгосугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



М.ГАНБААТАР

	ХАБЭА-н Эрсдэлийн үнэлгээний журам	СҮАЖ-ХЭҮЖ-009	БАТЛАВ ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ /...../ М.Ганбаатар
		Хувилбар: 1	Баталсан огноо: 2019 он сар өдөр
		Тушаал №	

ХАБЭА-Н ЭРСДЭЛИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ЖУРАМ

Ажилтан	Гарын үсэг	Овог нэр	Албан тушаал	Төлөв
Хянасан:	/...../	Д.Батбаатар	ХАБЭА-н Хэсгийн дарга	Тэмдэг
Боловсруулсан:	/...../ /...../	Э.Амарсайхан М.Баярцэнгэл	ХАБЭА-н бүртгэл хяналтын ажилтан	

Эрсдэлийн үнэлгээний журам	СҮАЖ-ХЭҮЖ-006
	Хувилбар: 1

БАРИМТ БИЧГИЙН ТҮҮХ			
Хувилбар	Өөрчлөлтийн утга	Боловсруулсан	Тушаалын дугаар/Огноо
1			

Эрсдэлийн үнэлгээний журам	СҮАЖ-ХЭҮЖ-006
	Хувилбар: 1

Агуулга

Нэг. Зорилго.....	4
Хоёр. Хамрах хүрээ	4
Гурав. Нэр томъёо, товчилсон үгийн тайлбар.....	4
Дөрөв. Зохион байгуулалт, үйл ажиллагаа, үүрэг.....	4
Тав. Аргачлал	6
Зургаа. Хариуцлага	10
Долоо. Хавсралт	10

Эрсдэлийн үнэлгээний журам	СҮАЖ-ХЭҮЖ-006
	Хувилбар: 1

Нэг. Зорилго

1.1. Энэхүү журмаар ажлын байр, ажилбарт үүсч болзошгүй аюулыг тогтоож, эрсдэлийг үнэлэх, хяналт тогтоох, дахин сайжруулах, эрсдэлээс үүдэлтэй осол гэмтэл гарахаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаатай холбоотой харилцааг зохицуулна.

Хоёр. Хамрах хүрээ

2.1. Энэхүү журмыг: “ТТТ” ХХК-ны алба хэлтэс, хэсэг нэгж гэрээгээр ажил үүрэг гүйцэтгэж байгаа иргэн, аж ахуйн нэгжийн ажилтнууд дагаж мөрдөнө.

Гурав. Нэр томъёо, товчилсон үгийн тайлбар

3.1. **Аюул гэж** ажилтныг гэмтээх, эрүүл мэндэд хохирол учруулах нөхцөл байдал буюу үйлдлийг хэлнэ.

3.2. **Эрсдэл гэж** ажилтныг үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалсан өвчлөлд хүргэж болзошгүй үйлдэл, нөхцөлийг хэлнэ.

3.3. **Эрсдэлийн үнэлгээ гэж** тухайн ажлын байранд удирдлага, ажилтан хамтран ажлын байрны эрсдэлд үнэлэлт өгөх үйл явцыг хэлнэ.

3.4. **Эрсдэлийн төвшин гэж** магадлал, үр дагаварын ноцтой байдлын хамрах хүрээ хэмжээг хэлнэ.

3.5. **Залруулах гэж** илэрсэн үл тохирол буюу бусад тааламжгүй, хүсээгүй байдлын шалтгааныг арилгахад чиглэсэн арга хэмжээг хэлнэ.

3.6. **Эрсдэлийн удирдлага гэж** ажлын байрны эрсдэлийг үнэлэх, устгах, бууруулах арга хэмжээг төлөвлөх, хэрэгжүүлэх, дахин үнэлэх, хяналт тогтоох үйл явцыг бүхэлд нь хэлнэ.

3.7. **Бүх шатны удирдлага гэж** ээлжийн ахлах, инженер, механик, хэсгийн дарга, албаны мэргэжилтэн, дарга, захирлуудыг хэлнэ.

3.8. ХАБЭАХХ – Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хяналтын хэсэг

3.9. ХАБЭА – Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй

Дөрөв. Зохион байгуулалт, үйл ажиллагаа, үүрэг

4.1. Эрсдэлийн үнэлгээг дараах нөхцөлд хийнэ:

4.1.1. Холбогдох хууль, эрх зүйн шаардлага өөрчлөгдсөн үед

4.1.2. Үйлдвэрлэлийн үйл ажиллагаа, ажлын байрны нөхцөл өөрчлөгдсөн тоног төхөөрөмж өргөтгөсөн, шинэчлэл засвар үйлчилгээ хийгдсэн үед,

Эрсдэлийн үнэлгээний журам	СҮАЖ-ХЭҮЖ-006
	Хувилбар: 1

4.1.3. Шинэ ажлын байр, тоног төхөөрөмжийг ашиглаж эхлэхээс өмнө

4.1.4. Ажлын байр, ажилбарт дүн шинжилгээ хийж, эрсдэлийг үнэлэх

4.1.5 Үйлдвэрлэлд ашиглагддаг түүхий эд материал өөрчлөгдсөн үед

4.2. Эрсдэлийг үнэлэхдээ тухайн ажлыг мэддэг мэргэшсэн удирдах ажилтан, дадлага туршлагатай ажилтнаас бүрдсэн баг байгуулна.

4.3. Багийн гишүүд нь эрсдэлийн үнэлгээ хийх аргачлал, ажлын зохион байгуулалт, бууруулах арга замыг тодорхойлох, багаар ажиллах мэдлэг, чадвар эзэмшсэн байна.

4.4. Хэсэг нэгжийн удирдлагын үүрэг.

4.4.1. Эрсдэлийн үнэлгээ хийх ажлын байрны жагсаалтыг гаргана.

4.4.2. Эрсдэлийг үнэлэх 3-аас дээш хүнтэй баг байгуулж, эрсдэлийг үнэлэх ажлыг зохион байгуулна.

4.4.3. Эрсдэлийн үнэлгээгээр нийт ажилтнуудад сургалт зохион байгуулна.

4.4.4. Эрсдэлийн үнэлгээг үндэслэн тухайн ажлын байр, ажилбарын аюулгүй ажиллагааны зааврыг шинэчлэн боловсруулж мөрдүүлнэ.

4.4.5. Аюулыг арилгах, эрсдэлийг бууруулах үйл ажиллагаанд ажилтнуудыг бүрэн хамруулж, тэдний санал, санаачлагыг дэмжин, идэвхижүүлнэ.

4.4.6. Ажилтны аюулгүй ажиллагааны зааварчилгаанд тухайн ажлын байр, ажилбарын аюул, эрсдэлийг заавал тусгана.

4.5. ХАБЭАХХ-ийн үүрэг.

4.5.1. Эрсдэлийн үнэлгээ хийх ажлын байрны жагсаалтыг хэсэг нэгжээс нэгтгэн авна.

4.5.2. ХАБЭА-н эрсдэлийн үнэлгээг төвшингээр нь эрэмбэлэн, хэсэг нэгжүүдийн эрсдэлд суурилсан ХАБЭА-н төлөвлөгөө, гүйцэтгэлд хяналт тавьж ажиллана.

4.5.3. Эрсдэлийг үнэлэх явц, эрсдэлийг устгах, залруулах төлөвлөгөө, гүйцэтгэлд хяналт тавьж, зөвлөмж, үүрэг даалгавар өгнө.

4.5.4. Зэргэлдээх байгууллагын орчны эрүүл ахуйн хэмжилт, үл тохирлыг залруулах арга хэмжээний төлөвлөгөөтэй танилцан, сөрөг хүчин зүйлийг бууруулах талаар хамтран ажиллана.

Эрсдэлийн үнэлгээний журам	СҮАЖ-ХЭҮЖ-006
	Хувилбар: 1

4.5.5. Гэрээт байгууллагын ХАБ-ын ажилтанд гүйцэтгэх ажил үйлчилгээтэй нь холбоотой эрсдэлийн үнэлгээ, аюулгүй ажиллагааны заавар, дүрэм, журмыг танилцуулж, аюул осолгүй ажиллуулах арга хэмжээг авахуулна.

Тав. Аргачлал

5.1. Аюулыг тогтоох, эрсдэлийг үнэлэх

5.1.1. аюулыг тогтоохдоо удирдлагын тогтолцоо, стандарт, дүрэм журам, заавар, ажлын байрны орчин, зохион байгуулалт, тоног төхөөрөмж, материал, ажилтны мэдлэг ур чадвар, амь нас, эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх гадны хүчин зүйл, ажлын байр ба ажилбарын үйлчлэлд өртөж болох бусад иргэн, ажилтны эрсдэлийг тооцно.

5.1.2. Эрсдэлийг үнэлэх үйл явц нь осол эрсдэлээс сэргийлэх, илрүүлэх, шалтгааныг олох, төвшингээр зэрэглэх, баримтжуулах, хянах боломжтой байна.

5.1.3. Эрсдэлийн үнэлгээ хийхдээ.

5.1.3.1. Ажилтнуудын эрүүл мэндийн үзлэг, хөдөлмөрийн чадвар алдалт, физиологийн судалгаануудад хийсэн дүгнэлт.

5.1.3.2. Хөдөлмөрийн нөхцөлийн хэмжилт, судалгаа, дүгнэлт.

5.1.3.3. Өмнөх эрсдэлийн үнэлгээ, хяналтын үзлэгийн тайлан.

5.1.3.4. Осол, осолд дөхсөн тохиолдлын бүртгэл, судалгаа.

5.1.3.5. Техник ашиглалтын паспорт, угсралт, суурилуулалтын акт, баталгаажуулалт, эвдрэл, гэмтлийн бүртгэл судалгаа.

5.1.3.6. Ажлын, тусгай хувцас, хамгаалах хэрэгслийн бүртгэл, судалгаа.

5.1.3.7. Химийн болон хортой бодисын мэдээлэл.

5.1.3.9. Хэмжилтийн багаж, техник хэрэгслийг ашиглана.

5.1.4. Үнэлгээний баг нь тухайн ажлын байранд ажиллагчтай хамтран эрсдэлийн үнэлгээ хийх ажилбарын жагсаалтыг гаргана.

5.1.5. Аюулыг тогтоох, эрсдэлийг үнэлэхдээ энэ журмын 5.1.3-т заасныг ашиглан, ажиглах, харилцан ярилцах аргаар “Ажлын байрны эрсдэлийн үнэлгээ” (Хавсралт №1)-г хийнэ.

Эрсдэлийн үнэлгээний журам	СҮАЖ-ХЭҮЖ-006
	Хувилбар: 1

5.1.6 Ажилбарын дарааллын дагуу үйлдэл болгоны болзошгүй аюул эрсдэлийг тогтоон, үр дагавар, магадлалыг тооцох хүснэгтийг ашиглан, эрсдэлийн төвшинг өндөр эрсдэлтэй, бага эрсдэлтэй гэсэн ангилалаар тогтооно.

Эрсдэлийн үр дагаврыг тооцох хүснэгт

Зэрэглэл	Хохирлын зэрэг ба эвдрэлийн хэмжээ	Эмнэлгийн тусламж ба ХЧТА
1	Ялимгүй (тоног төхөөрөмж, машин механизм эвдрээгүй)	Шаардлагагүй, түр саатах
2	Бага зэрэг (тоног төхөөрөмж, машин механизмд үзлэг хяналт хийх)	Анхны тусламж авах, ажлын ээлжийн хугацаанд өвчлөх
3	Дунд зэрэг (тоног төхөөрөмж, машин механизмыг сэргээн засварлах, тохируулах)	Эмчилгээ хийлгэх, 4 хүртэл хоногоор өвчлөх
4	Их хэмжээний (тоног төхөөрөмж, машин механизмыг сэлбэн засварлах, нэмэлт хөрөнгө оруулалт хийх)	Удаан хугацаанд эмчилгээ хийлгэх буюу 4-өөс дээш хоногоор өвчлөх
5	Ноцтой (тоног төхөөрөмж, машин механизмд их засвар хийх)	Тахир дутуу болгох, үхэлд хүргэх, 3 сараас дээш, удаан хугацаанд өвчлөх

Эрсдэлийн магадлалыг тооцох хүснэгт

Үнэлгээ	Тохиолдох давтамж	Давтагдах хугацаа
А	Байнга, үргэлж	Өдөр бүр, үргэлж
Б	Тохиолдоно	Долоо хоног тутам
В	Тохиолдож болзошгүй	Сар тутам
Г	Хааяа тохиолдоно (Магадлал бага)	Улирал тутам
Д	Маш ховор (Бараг боломжгүй)	Хааяа

Эрсдэлийн үнэлгээний журам	СҮАЖ-ХЭҮЖ-006
	Хувилбар: 1

Эрсдэлийн төвшин тогтоох хүснэгт

Эрсдэлийн төвшин тогтоох хүснэгт						
	1	2	3	4	5	
А	11	16	20	23	25	17-25 оноо, Өндөр эрсдэлтэй, Бүү хий! Ахлах ажилтанд мэдэгд, тохирсон арга хэмжээ авч ажилла.
Б	7	12	17	21	24	
В	4	8	13	18	22	
Г	2	5	9	14	19	6-16 оноо, Эрсдэлтэй, Аюулд хяналт тогтоо.
Д	1	3	6	10	15	1-5 оноо, Бага эрсдэлтэй, Аюулын нөхцөл байдал өөрчлөгдөж болзошгүйг анхаар.
Даалгавараа аюулгүй гүйцэтгэх цаг хугацаа гарга						

5.1.7. төвшин нь 17-25 бол өндөр эрсдэлтэй гэж үзэх бөгөөд ноцтой осолд хүргэж болзошгүй тул ажлыг зогсоон, зардал, өртгөөс үл хамааран нэн даруй залруулах, хүлээн зөвшөөрөхүйц төвшин хүртэл бууруулах арга хэмжээ авна.

5.1.8. Төвшин нь 6-1. Бол эрсдэлтэй гэж үзэх бөгөөд тогтмол хяналт тавьж, эрсдэлийг удирдах, бууруулах, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн стандарт, дүрэм, журмын шаардлагыг хангах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

5.1.9. Төвшин нь 1-5 бол бага эрсдэлтэй гэж үзэх бөгөөд эрсдэлийг удирдах, бууруулах арга хэмжээ шаардлагагүй боловч тогтмол хяналт тавьж, заавар, журмыг чанд мөрдүүлж ажиллана.

5.1.10. Аюул эрсдэлийг устгах, залруулах арга хэмжээ, бууруулсны дараах эрсдэлийн төвшин, нэмэлт арга хэмжээг үнэлгээнд тусгана.

5.1.11. Хэсгийн инженер нь эрсдэлийн үнэлгээ хийгдсэн ажлын байрны жагсаалт, төвшин (Хавсралт №2)-г нэгтгэн гаргана.

5.1.12. Хэлтэс, алба, Хэсгийн дарга нь эрсдэлийн үнэлгээг зөвөлгөөнөөрөө хэлэлцэн, ХАБЭАХ-ээр хянуулж батална.

Эрсдэлийн үнэлгээний журам	СҮАЖ-ХЭҮЖ-006
	Хувилбар: 1

5.1.13. ХАБЭАХ нь эрсдэлийн үнэлгээг нэгтгэн, Гүйцэтгэх захирлын тушаалаар баталгаажуулна.

5.2. Эрсдэлийг устгах, залруулах ажлыг төлөвлөх, хэрэгжүүлэх

5.2.1. Хэсэг нэгжийн удирдлага нь эрсдэлийн үнэлгээ, эрсдэлийн үнэлгээ хийгдсэн ажлын байрны жагсаалт, төвшинг үндэслэн “Эрсдэлийг устгах, залруулах ажлын төлөвлөгөө” (хавсралт №3)-г боловсруулан, батлуулж хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна.

5.2.2. Эрсдэлийг бууруулахдаа дараах аргуудыг ашиглана.

5.2.2.1. Устгах (аюулыг шууд устгах буюу үгүй болгох арга хэмжээ авах)

5.2.2.2. Орлуулах буюу солих (аюул багатай материал, тоног төхөөрөмжөөр солих, орлуулах, хүчин чадлыг бууруулах г.м)

5.2.2.3. Техникийн хяналт, инженеринг хийх (нэмэлт арга хэмжээ авах, агааржуулах, хаалт, хашилт, хамгаалалт хийх, дуу чимээг тусгаарлах г.м)

5.2.2.4. Захиргааны хяналт тавих (аюулгүйн тэмдэг, бүсийн тэмдэглэгээ, гэрэл ойлгогчтой тэмдэг, санамж, анхааруулга, замын тэмдэг, анхааруулах гэрэл, дуут дохио, дохиолол, АА-ны заавар, журмууд, аюулгүй ажиллах арга барил, хаягжуулалт, шошгожуулалт, зааварчилгаа олголт г.м)

5.2.2.5. Хувийн хамгаалах хэрэгсэл ашиглах (толгой, нүүр, нүд, сонсгол, амьсгал хамгаалах хэрэгслүүд, аюулгүй бэхэлгээ, өндрийн бүс, хорт хийн баг, ажлын тусгай гутал, хувцас, бээлий г.м)

5.2.3. “Эрсдэлийг устгах, залруулах ажлын төлөвлөгөө”-нд хариуцах ажилтан, хугацаа, шаардлагатай нөөц, зардлыг заавал тусгана.

5.3. эрсдэлийн үнэлгээг дахин хянах, сайжруулах, баримтжуулах

5.3.1. Ажлын байр, ажилбарт өөрчлөлт шинэчлэлт, аюул эрсдэл гаргаагүй бол эрсдэлийн үнэлгээг жил бүр сайжруулалт хийнэ.

5.3.2. Эрсдэлийн үнэлгээг төвшингээр нь эрэмбэлсэн жагсаалтын дагуу төвшинг бууруулах үйл ажиллагааг хянана.

5.3.3. Эрсдэлийн үнэлгээ, жагсаалт, төлөвлөгөөг баримтжуулан хадгална.

Эрсдэлийн үнэлгээний журам	СҮАЖ-ХЭҮЖ-006
	Хувилбар: 1

Зургаа. Хариуцлага

6.1. Журмыг зөрчсөн ажилтанд Хөдөлмөрийн тухай хууль, ХАБЭА-н тухай хууль

Долоо. Хавсралт

7.1. Хавсралт №1 Ажлын байрны эрсдэлийн үнэлгээний маягт

7.2. Хавсралт №2 Эрсдэлийн үнэлгээ хийгдсэн ажлын байрны жагсаалт

7.3. Хавсралт №3. Эрсдэлийг устгах, залруулах ажлын төлөвлөгөө

Батлав:

Ажлын байрны эрсдэлийн үнэлгээ

Хэсэг, нэгжийн нэр:

Ажлын байр:

Огноо:

№	Ажил гүйцэтгэх дараалал буюу ажилбарын нэр	Болзошгүй аюул, эрсдэл	Үнэлэх үеийн үзүүлэлт			Аюул, эрсдэлийг бууруулах, устгах арга хэмжээ	Бууруулсны дараах үзүүлэлт			Нэмэлт арга хэмжээ
			Эрсдэлийн үр дагавар	Гарах магадлал	Эрсдэлийн төвшин		Эрсдэлийн үр дагавар	Гарах магадлал	Эрсдэлийн төвшин	
	а	б	в	г	д	е	ё	ж	з	и
1										
2										
3										
4										
5										
6	Эрсдэлийн үнэлгээ									

Эрсдэлийн үнэлгээг хийсэн багийн гишүүд:

.....

Хянасан:

.....

Тайлбар:

1. Эрсдэлийн үнэлгээг тухайн хэсгийн дарга батална.
2. Хэсэг, нэгжийн нэр: Эрсдэлийн үнэлгээ хийж буй хэсгийн нэрийг бичнэ.
3. Ажлын байр: Үнэлгээ хийж буй ажлын байр, машин техник, тоног төхөөрөмжийн нэр, марк, дугаарыг бичнэ.
4. Огноо: Үнэлгээ хийж буй он сар өдрийг бичнэ.
5. Ажил гүйцэтгэх дараалал буюу ажилбарын нэр: Тухайн ажлын байранд эвсэл машин техник, тоног төхөөрөмжөөр хийж гүйцэтгэх ажил, ажилбарыг дарааллын дагуу бичнэ.
6. Болзошгүй аюул, эрсдэл: Ажлын дараалал, ажилбар бүрд учирч болзошгүй аюул эрсдэлийг тодорхойлно.
7. Үнэлэх үеийн эрсдэлийн үр дагавар: осол, техникийн эвдрэл, ХЧТА-ын судалгаа, эрсдэлийн үр дагаврыг тооцох хүснэгтийг ашиглан, гишүүн тус бүрийн саналыг үндэслэн тооцно.
8. Үнэлэх үеийн гарах магадлал: Осол, техникийн эвдрэл, ХЧТА-ын судалгаа, магадлал тооцох хүснэгтийг ашиглан, гишүүн тус бүрийн саналыг үндэслэн тооцно.
9. Үнэлэх үеийн эрсдэлийн төвшин: эрсдэлийн төвшин тогтоох хүснэгтийг ашиглан тогтооно.
10. Аюул, эрсдэлийг устгах, залруулах арга хэмжээ: Тухайн ажлын байр, ажилбарын эрсдэлийг устгах, бууруулахын тулд авах арга хэмжээг тодорхойлно. Энэ үзүүлэлт нь аюул, эрсдэлийг устгах, бууруулах ажлыг төлөвлөх, гүйцэтгэлийг хангахад чухал нөлөөтэй тул устгах, орлуулах буюу солих, техникийн хяналт буюу инженеринг хийх, захиргааны хяналт тавих, хувийн хамгаалах хэрэгсэл ашиглах аргуудаас зөв сонгон тодорхойлох шаардлагатай.
11. Бууруулсны дараах эрсдэлийн үр дагавар: Эрсдэлийг устгах, бууруулах арга хэмжээ авсны дараах байдлыг үнэлнэ.
12. Бууруулсны дараах гарах магадлал: Эрсдэлийг устгах, бууруулах арга хэмжээ авсны дараах байдлыг үнэлнэ.
13. Бууруулсны дараах эрсдэлийн төвшин: Эрсдэлийг устгах, бууруулах арга хэмжээ авсны дараах төвшинг тогтооно.
14. Нэмэлт арга хэмжээ: Аюул эрсдэлийг устгах, бууруулах арга хэмжээ авахад шаардлагатай материал, багаж, хамгаалах хэрэгслийг бичнэ.
15. Ажлын байрны эрсдэлийн төвшин: Ажлын дараалал, ажилбарын үнэлэх үеийн (сүүлийн мөрний д багана) ба бууруулсны дараах (сүүлийн мөрний з багана) эрсдэлийн төвшингийн дундач
16. Эрсдэлийн үнэлгээг хийсэн багийн гишүүд: Гишүүдийн нэр ба гарын үсэг байна.
17. Хянасан: ХАБЭАХ-ийн дарга, инженерийн нэр ба гарын үсэг байна.

Батлав: Хэсгийн дарга

/

..... хэсгийн эрсдэлийн үнэлгээ хийгдсэн ажлын байрны жагсаалт

№	Ажлын байрны нэр	Үнэлгээ хийсэн ажилтан		Эрсдэлийн төвшин	
		Албан тушаал	Нэр	Үнэлэх үеийн	Бууруулсны дараах
	а	б	в	г	д
1					
2					
3					
4					
5					
6					
7	<u>Өндөр эрсдэлтэй</u> . Бүү ажилла. Яаралтай устгах, залруулах арга хэмжээ ав.		17-25		
8	<u>Эрсдэлтэй</u> . Хяналт тогтоож, залруул.		6-16		
9	<u>Бага эрсдэлтэй</u> . Өөрчлөгдөж болзошгүйг анхаарч байнгын хяналт тавь.		1-5		
10	Хэсгийн эрсдэлийн төвшин				

Жагсаалтыг нэгтгэсэн:

/

Жишээ тайлбар:

1. 7-г ба 7-д өндөр, 8-г ба 8-д эрсдэлтэй, 9-г ба 9-д бага эрсдэлтэй ажлын байрны тоог бичнэ.
2. 10-г ба 10-д эрсдэлийн төвшингийн дунджийг тавина.
3. Өндөр эрсдэлтэй ажлын байрны төвшинг улаан эрсдэлтэйг шар, бага эрсдэлтэйг ногоон өнгөөр тус тус тэмдэглэнэ.

Батлав: Гүйцэтгэх захирал М.Ганбаатар /

/

..... хэсгийн эрсдэлийг устгах, залруулах ажлын төлөвлөгөө

№	Ажлын байр, ашиглах тоног төхөөрөмжийн нэр марк	Ажил гүйцэтгэх дараалал буюу ажилбарын нэр	Болзошгүй аюул, эрсдэл	Үнэлэх үеийн			Аюул, эрсдлийг усгах, залруулах арга хэмжээ	Хийх хугацаа	Хариуцах эзэн	Санхүүжилт	Бууруулсны дараах		
				Эрсдэлийн үр дагавар	Гарах магадлал	Эрсдэлийн төвшин					Эрсдэлийн үр дагавар	Гарах магадлал	Эрсдэлийн төвшин
0	а	б	в	г	д	е	ё	ж	з	и	й	к	л
1													
2													
3													
4													
5													
6	Эрсдэлийн төвшин												

Төлөвлөсөн: Хэсгийн Ахлах /

/

Хянасан: Үйлдвэрлэлийн албаны дарга М.Болдбаяр /

/

ХАБЭАХХ-ийн дарга Д.Батбаатар /

/